



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/298

Улаанбаатар хот

Бүтэц, орон тоо, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Иргэний нисэхийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэхтэй холбогдуулан “Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-ны нэрийг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба” гэж өөрчилсүгэй.

2. “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-ны дүрмийг нэгдүгээр хавсралтаар, тус албаны зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталж, орон тооны дээд хязгаарыг 12 байхаар тогтоосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Болор-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарахтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын “Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай” 2018 оны 171 дүгээр тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.ДЭЛГЭРСАЙХАН

Зам, Тээврийн сайдын 20... оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот
тушаалын Нэгдүгээр хавсралт

“АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА”-НЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид Алба гэх) нь Чикагогийн конвенцын¹ Хавсралт 13 “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай” /цаашид Хавсралт 13 гэнэ/, Иргэний нисэхийн тухай /шинэчилсэн найруулга/ Монгол Улсын хуулийн 9 дүгээр бүлэгт заасны дагуу үйл ажиллагаа явуулах, шинжлэн шалгах эрх бүхий байгууллага мөн.

1.2. Алба нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд, түүний шууд удирдлагад дор бие даасан үйл ажиллагаа явуулна.

1.3. Энэхүү дүрмийн зорилго нь Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.4. Алба нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бие даасан байдлаар ажиллана.Үүнд:

1.4.1. Албаны үйл ажиллагаа явуулах болон шинжлэн шалгагчдын ур чадварыг дээшлүүлэх зардлын төсөвтэй байна; /Иргэний нисэхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт/

1.4.2. улс төр болон хөндлөнгийн дарамт шахалтаас ангид байна.

1.5. Албаны дүрэм, бүгэц зохион байгуулалт, орон тоо болон үйл ажиллагааны зардлын төсвийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.6. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Албаны дарга бөгөөд Ерөнхий шинжлэн шалгагчийг, хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

1.7. Алба нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4.7 заалтын дагуу Ерөнхий шинжлэн шалгагчийн баталсан “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах бодлогын заавар”, “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах заавар”, “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажлыг зохион байгуулах заавар”, “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах сургалт, дадлагын заавар” болон бусад холбоотой дүрмийг удирдлага болгоно.

1.8. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын удирдамж, заавруудад тулгуурлан боловсруулсан техник, технологийн баримт бичгүүдийг Иргэний нисэхийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 50.1 дэх хэсэгт заасны дагуу англи хэл дээр ашиглаж болно.

1.9. Алба нь зохих журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх ба өөрийн бэлгэдэлтэй байна.

Хоёр. Албаны бүрэн эрх, үйл ажиллагаа

2.1. Алба нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд болсон аливаа улсын иргэний агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгана.

¹1944 оны Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, Монгол Улс 1989 онд нэгдэн орсон.

² Чикагогийн Конвенцын 13 дугаар хавсралтын 3 дугаар бүлгийн 2 дах заалт, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /цаашид “ICAO” гэх/-ын Doc9962-ийн 3.3 зүйлийн 3.3.2. а), b), c) заалт

2.2. Осолд хүргэж болзошгүй гэж үзсэн агаарын хөлгийн зөрчлийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Ерөнхий шинжлэн шалгагчийн шийдвэрээр шинжлэн шалгана.

2.3. Хэлэлцэн тохирогч бус улсын нутаг дэвсгэрт Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт тохиолдсон осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг дараах тохиолдолд Олон улсын гэрээ, Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

2.3.1. тухайн улс шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхгүй;

2.3.2. тухайн улс шинжлэн шалгах ажиллагааг 13 дугаар Хавсралтын дагуу бус, өөр зорилгоор гүйцэтгэх бол.

2.4. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна Монгол Улсад бүртгэлтэй эсхүл Монгол Улсын тээвэрлэгчийн иргэний агаарын хөлөгт тохиолдсон осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд 13 дугаар Хавсралтын 5 дугаар бүлгийн 5.18 заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу оролцоно.

2.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд тухайн агаарын хөлгийн бүртгэгч улс, зохион бүтээгч улс, үйлдвэрлэгч улс болон тээвэрлэгчийг харьяалах улсын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг 13 дугаар Хавсралтын 5 дугаар бүлгийн 5.18-т заасан эрх үүргийн дагуу оролцох нөхцөл боломжоор хангана.

2.6. Шаардлагатай тохиолдолд дараах шинжлэн шалгах ажиллагааг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэрлүүлнэ. Үүнд:

2.6.1. Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэх эрхийг хэлэлцэн тохирогч улсын шинжлэн шалгах эрх бүхий байгууллагад хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэх;

2.6.2. Монгол Улсад бүртгэгдсэн агаарын хөлөг далайн олон улсын бүс, нээлттэй далайд осолд орсон тохиолдолд бусад хэлэлцэн тохирогч улсаас тусламж хүсэх.

2.7. Шинжлэн шалгах ажлыг үр дүнтэй, шуурхай явуулахын тулд эрдэм шинжилгээ, бичлэг тайлах лаборатори болон шаардлагатай тоног төхөөрөмжийг эзэмшигчидтэй хамтран ашиглаж, ажиллаж болно.

2.8. Шинжлэн шалгах ажиллагааны явцад аюулгүй байдлын хяналт зохицуулалтын чиг үүрэг бүхий иргэний нисэхийн төрийн захиргааны байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хэний ч шахалт дарамтад үл орж, бусад хэлбэрээр нөлөөлөлд автахгүй байна.

2.9. Шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор олж авсан бичлэг, нэмэлт мэдээллүүдийг осол, зөрчлийн шалтгааныг тогтоохоос өөр зорилгоор ашиглахгүй, эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх үүрэгтэй. Үүнд:

2.9.1. шинжлэн шалгах ажиллагааны явцад аливаа этгээдээс авсан тайлбар, тодорхойлолт;

2.9.2. агаарын хөлгийн бүхээгийн доторх дүрс болон ярианы бичлэг, газартай харьцсан ярианы бичлэг;

2.9.3. аливаа этгээдийн эрүүл мэндийн талаарх эмнэлгийн дүгнэлт болон хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл;

2.9.4. шинжлэн шалгах ажиллагаанд оролцогчийн илэрхийлсэн санал, дүгнэлт;



- 2.9.5. нислэгийн болон бүхээгийн ярианы бичлэгийн талаарх шинжээчийн үнэлэлт, санал;
- 2.9.6. агаарын хөлгийн ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой этгээдүүдийн захидал харилцаа гэх мэт.

2.10. Шүүх, хууль хяналтын байгууллагаас нууц мэдээллийг нээлттэй болгох, үр дүн нь хийгдэж буй эсвэл ирээдүйд хийгдэх шинжлэн шалгах ажиллагаанд үзүүлэх дотоод, гадаад сөрөг хүчин зүйлээс илүү ач холбогдолтойг тогтоосноос бусад тохиолдолд нууцлалд хамаарах мэдээлэл болон 13 дугаар Хавсралтын 5 дугаар бүлгийн 5.12.3-т заасны дагуу осол, зөрчилтэй холбогдсон хувь хүний овог, нэрийг нийтэд ил гаргахгүй байна.

2.11. Алба нь агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл гарган осол, зөрчилтэй холбогдсон хуулийн этгээдэд хүргүүлж, 13 дугаар Хавсралтын 6 дугаар бүлгийн 6.3-д заасны дагуу үндэслэл бүхий зарчмын саналыг 60 хоногт багтаан авч эцсийн тайланг гаргана. Хүлээн авах боломжгүй гэж үзсэн саналыг тайланд хавсаргана. Хэрэв 60 хоногийн хугацаанд зарчмын санал хүлээн аваагүй бол эцсийн тайланг санал хүлээлгүй гаргана.

2.12. Осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг 13 дугаар Хавсралтын 6 дугаар бүлгийн 6.5-т заасны дагуу аль болох хурдан, боломжтой тохиолдолд 12 сарын дотор нийтэлж, албаны цахим хуудсанд байршуулна.

2.13. Урьдчилсан тайлан эсвэл бичиг баримтыг албан ёсоор гаргаж нийтлээгүй тохиолдолд тайлан, түүний хэсэг эсвэл шинжлэн шалгах ажиллагааны бусад баримт бичгийг Ерөнхий шинжлэн шалгагчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлэхгүй, мөн түгээх болон бусдад задруулахыг хориглоно.

2.14. Шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон бусад эх үүсвэрийг үндэслэн агаарын хөлгийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг Иргэний нисэхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн дагуу зохион байгуулна.

2.15. Шинжлэн шалгах ажлыг үр дүнтэй явуулахын тулд олон улсын болон төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж болно.

Гурав. Албаны зохион байгуулалт, бүтэц

3.1. Алба нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нийцсэн, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэх тогтолцоо бүхий бүтэцтэй байна.

3.2. Албаны бүтэц нь Шинжлэн шалгах тасаг болон Захиргаа, судалгааны тасгуудаас бүрдэнэ.

3.3. Шинжлэн шалгах тасаг дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

3.3.1. нислэг, нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд болон түүний холбогдох бичиг баримтад дүн шинжилгээ хийх;

3.3.2. агаарын хөлгийн систем, эд ангиудад судалгаа, шинжилгээ хийх;


3.3.3. агаарын хөлгийн хөдөлгүүр, түүний эд ангиудад судалгаа, шинжилгээ хийх;

3.3.4. агаарын хөлгийн бүтэц, хүчилсэн эд ангид судалгаа, шинжилгээ хийх;


3.3.5. техник үйлчилгээ, техник үйлчилгээний бичиг баримтад судалгаа, шинжилгээ хийх;

3.3.6. шаардлагатай тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд болон холбогдох бичиг баримтад дүн шинжилгээ хийх;

3.3.7. шаардлагатай тохиолдолд нисэх буудлын үйл ажиллагаанд болон холбогдох бичиг баримтад дүн шинжилгээ хийх;



- 3.3.8. холбогдох цаг агаарын байдалд судалгаа, шинжилгээ хийх;
- 3.3.9. агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл, бүхээгийн ярианы бичлэгийг унших, дүн шинжилгээ хийх;
- 3.3.10. эвдэрч, гэмтэж тарсан эд ангийн байршлыг тогтоож нарийвчилсан зураг гаргах, ослын газрыг шинжлэн судлах;
- 3.3.11. ослын газрын болон эвдэрсэн эд ангийн нарийвчилсан зураг авах, дүрс бичлэг хийх;
- 3.3.12. осол, зөрчлийн мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийх;
- 3.3.13. металлын үл эвдэх болон эвдэх сорилт шинжилгээний ажлыг зохион байгуулах, үр дүнд дүн шинжилгээ хийх;
- 3.3.14. агаарын хөлгийн шингэний болон шатах, тослох материалын дээжийн шинжилгээг зохион байгуулах, үр дүнд дүн шинжилгээ хийх;
- 3.3.15. осол зөрчилд нөлөөлөх хүний хүчин зүйлсийн судалгаа, шинжилгээ, холбогдох зааврын дагуу шинжлэн шалгах ажиллагаа явуулах;
- 3.3.16. зорчигчийн бүхээгийн аюулгүй ажиллагаа, галтай тэмцэх ажиллагааны зохион байгуулалтыг шинжлэн судлах;
- 3.3.17. эрэн хайх, авран туслах ажлын зохион байгуулалт, амьд гарах чадвар, эрсдэлийн эх үүсвэрийг шинжлэн судлах;
- 3.3.18. шаардлагатай тохиолдолд нисгэх баг, хохирогчдын эрүүл мэндийн байдалд судалгаа хийх, холбогдох зааврын дагуу шинжлэн шалгах ажиллагаа явуулах;
- 3.3.19. гэрч болон хохирогчийн ойр дотнын хүмүүсээс мэдээлэл авах;
- 3.3.20. агаарын тээврийн байгууллагын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх;
- 3.3.21. иргэний нисэхийн хяналт зохицуулалтын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх;
- 3.3.22. осол, зөрчлийг шинжлэн шалгасан ажлын тайланг гаргах;
- 3.3.23. шинжлэн шалгасан ажлын үр дүнд тулгуурлан шаардлагатай аюулгүй байдлын зөвлөмж бэлтгэх;
- 3.3.24. аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.3.25. осол, зөрчлийн мэдээллийг байнга авах ажлыг зохион байгуулах.
- 3.4. Захиргаа, судалгааны тасаг дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 3.4.1. шинжлэн шалгасан ажлын тайлангийн бүртгэл, хадгалалтыг зохион байгуулах;
- 3.4.2. осол, зөрчлийг бүртгэл ажлыг зохион байгуулах;
- 3.4.3. шинжлэн шалгасан ажлын тайланг олон улсын иргэний нисэхийн байгууллагын хүлээн зөвшөөрөгдсөн аль нэг хэл дээр орчуулах, олон улсын байгууллага болон холбогдох улсуудад илгээх ажлыг зохион байгуулах;
- 3.4.4. Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэх;
- 3.4.5. аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх;



3.4.6. албаны төсөв, хөрөнгө, санхүүгийн бүртгэл хөтлөх, улирал болон жилийн тайлан гаргах;

3.4.7. албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлыг зохион байгуулах;

3.4.8. хүний нөөц, ажилтнуудын мэдээллийн сан бүрдүүлэх, мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, сургалт зохион байгуулах, хувийн хэрэг хөтлөх;

3.4.9. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл зэргийн нөөцийг бүрдүүлэх, байнгын бэлэн байдалд байлгах, шаардлагатай тээвэр, хувийн эрүүл мэнд болон хөдөлмөр хамгааллын хэрэгслийг бэлдэх;

3.4.10. олон улсын иргэний нисэхийн байгууллагаас агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах талаар тавигдаж байгаа зорилго, ач холбогдлыг олон нийтэд танилцуулж сурталчлах;

3.4.11. агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл, бүхээгийн ярианы бичлэгийг татан авах, тайлж унших ажиллагааг хийж шинжлэн шалгах багийн ахлагчид хүлээлгэн өгөх;

3.4.12. иргэд хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.

Дөрөв. Албаны удирдлага

4.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдана. Ерөнхий шинжлэн шалгагч нь түүнийг томилсон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнаж, түүний өмнө хариуцлага хүлээнэ.

4.2. Албаны Ерөнхий шинжлэн шалгагч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

4.3. Ерөнхий шинжлэн шалгагч эзгүй байх хугацаандаа албан үүргээ ахлах шинжлэн шалгагч болон аль нэг шинжлэн шалгагчид түр орлуулан гүйцэтгүүлэх бөгөөд энэ нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

4.4. Ерөнхий шинжлэн шалгагч нь Иргэний нисэхийн тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1. албаны зорилт, чиг үүргийг биелүүлэх ажлыг хариуцах;

4.4.2. батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

4.4.3. батлагдсан бүтэц, орон тоо болон эрх хэмжээний хүрээнд албаны ажилтнуудыг томилох, чөлөөлөх;


4.4.4. албыг гадаад, дотоодод төлөөлөх, бусад байгууллагатай харьцах;

4.4.5. хууль дүрмийн дагуу албаны шинжлэн шалгагч болон ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах болон сахилгын шийтгэл ноогдуулах;

4.4.6. холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулж баталж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.4.7. албаны үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээг авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлэх;

4.4.8. сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;



4.4.9. ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

4.4.10. хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах, дотоод дүрэм, заавруудыг батлах;

4.4.11. дээд удирдлага болон олон улсын иргэний нисэхийн байгууллагыг агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн талаарх мэдээллээр холбогдох журмын дагуу хангах;

4.4.12. осол, зөрчлийг шинжлэн шалгах ажилд шаардлагатай гарын авлага, материалуудыг бэлтгэн хэвлүүлэх;

4.4.13. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжид орсон нэмэлт өөрчлөлт болон тусгагдаагүй зүйлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, заавруудад тухай бүр тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4.4.14. шинжлэн шалгах ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомжид Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжөөс ялгаатай заалт байвал тус байгууллагад мэдэгдэх;

4.4.15. осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг хариуцан гүйцэтгэх шинжлэн шалгагч болон багийг томилох;

4.4.16. осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг шуурхай зохион байгуулах;

4.4.17. осол, зөрчлийн газарт шинжлэн шалгагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.4.18. шинжлэн шалгах ажлыг шуурхай үр дүнтэй зохион байгуулах зорилгоор төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог хангах;

4.4.19. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна, Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг осол, ноцтой зөрчилд орсон тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

4.4.20. гадаад улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчилд Монгол Улсын иргэн олноор өртсөн тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд оролцох экспертийг томилох;

4.4.21. шинжлэн шалгах ажлыг үр дүнтэй явуулахын тулд төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж ажиллах;

4.4.22. шинжлэн шалгагч ажил үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж, хяналт тавих;

4.4.23. шинжлэн шалгасан ажиллагааны тайлан, аюулгүй байдлын зөвлөмжийг гаргах;


4.4.24. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, тоног төхөөрөмж, багаж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр ажилтнуудыг хангах, зохих нөөцийг бүрдүүлэх;

4.4.25. шинжлэн шалгагч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан стандарт, зөвлөмжид тусгагдсан шаардлагатай нийцүүлэх арга хэмжээг авах;

4.4.26. шинжлэн шалгагчийн суурь мэргэжил /нисгэгч, инженер, нислэгийн удирдагч/-ийн ур чадварыг хадгалах үйл ажиллагааг "Шинжлэн шалгагчийн ур чадварыг хадгалах журам"-аар зохицуулсан байна.

Тав. Хүний нөөцөд тавигдах шаардлага

5.1. Алба нь осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэх Ерөнхий шинжлэн шалгагч, ахлах шинжлэн шалгагч, шинжлэн шалгагч болон бусад ажилтнаас бүрдэнэ.



5.2. Шинжлэн шалгагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.2.1. Мэргэжлийн нисгэгч, агаарын хөлгийн инженер, нислэгийн хөдөлгөөний удирдлагын мэргэжилтэй, мэргэжлээрээ дээд боловсролтой байх;

5.2.2. Нисэхийн салбарт 5.2.1-т дурдсан чиглэлээр 10-15 жил ажилласан дадлага, туршлагатай, шинжлэн шалгах ур чадварыг эзэмшсэн байх.

5.2.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлын удирдлага зохион байгуулалт болон хүний хүчин зүйл зэрэг нисэхийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцан хамаарлын талаар мэдлэгтэй байх.

5.3. Ахлах шинжлэн шалгагч нь шинжлэн шалгагчид тавигдах шаардлагыг хангасан, мэргэжлээрээ 15-аас дээш жил ажилласан шинжлэн шалгагчаар 3-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай байна.

5.4. Шинжлэн шалгагч, ахлах шинжлэн шалгагч болон бусад ажилтан тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг ерөнхий шинжлэн шалгагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

Зургаа. Нөөц шинжлэн шалгагч

6.1. Алба нь шинжлэн шалгах ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүлэх зорилгоор тусгай мэргэжлийн нөөц шинжлэн шалгагчийг бэлтгэсэн байна.

6.2. Нөөц шинжлэн шалгагч нь шинжлэн шалгагчид тавигдах мэдлэг, туршлага, ур чадварын шаардлагыг хангасан байна.

6.3. Томилогдсон нөөц шинжлэн шалгагч нарын бэлэн байдлыг хангах үүднээс анхан болон давтан сургалтуудад холбогдох зааврын дагуу хамруулан ур чадварыг дээшлүүлж болно.

6.4. Ерөнхий шинжлэн шалгагч нь шаардлагатай тохиолдолд нөөц шинжлэн шалгагчийг шинжлэн шалгагчаар томилох саналыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргана.

Долоо. Албаны төсөв, санхүүжилт

7.1. Албаны үйл ажиллагааны жилийн тогтмол зардал болон осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд шаардагдах зардлыг агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоор санхүүжүүлнэ.

7.2. Алба нь осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд шаардагдах дараах зардлын төсөвтэй байна. Үүнд:

7.2.1. Гадаад улсад томилогдон ажиллах шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зардал;

7.2.2. Гадаад болон дотоодын байгууллагуудаас шинжлэн шалгах ажиллагаанд авч ажиллуулж байгаа мэргэжилтэн, шинжлэн шалгагч нарын зардал;


7.2.3. Туршилт, шинжилгээ, судалгаа, бичлэг тайлах зардал;

7.2.4. Шинжлэн шалгасан ажлын тайланг гадаад улс болон олон улсын байгууллагад илгээхтэй холбоотой орчуулга, ослын эд мөрийн баримт, материал болон бусад зардал.

Найм. Бусад

8.1. Энэхүү дүрмийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Зам, Тээврийн сайдын 20...-оны
... дугаар сарын...-ны өдрийн
тоот тушаалын Хоёрдугаар хавсралт

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА /12/

Дарга, ерөнхий шинжлэн шалгагч – 1

Шинжлэн шалгах тасаг /6/

Ахлах шинжлэн шалгагч - 1
Нислэгийн шинжлэн шалгагч – 2
Нислэгийн хөдөлгөөний шинжлэн
шалгагч - 1
Техникийн шинжлэн шалгагч - 2

Захиргаа, судалгааны тасаг /5/

Санхүү, нягтлан бодогч – 1
Бүртгэл, судалгааны мэргэжилтэн – 1
Гадаад харилцаа, хуулийн мэргэжилтэн - 1
Бичиг хэрэг, туслах ажилтан – 1
Технологийн жолооч - 1

Нийт орон тоо -12